Засгийн газрын хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ТАСГИЙН БАЙЦААГЧ АЮУШЖАВЫН ЭНХЖАРГАЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ.ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | |
|---|---|---|---|---|
| | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт |
| 1 | 2 | 3 | 4 | 5 |

НЭГ. " БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

***Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх,үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах.***

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.1.1 | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах. | Хэрэгжүүлсэн дүрэм, журам,заавар,зөвлөмж, аргачлал,чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг | Улсын их хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталсан. Хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.Үүнд: |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | зохион байгуулсан байна. | -Дараалсан 6 ба 7 жилийн дундаж цалинг 5 жил болгон өөрчилсөнтэй холбоотойгоор нийт **2865** тэтгэврийг өөрчлөн тогтоож тогтоолтын хуудсыг хянаж, хувийн хэрэгт хавсаргасан.<br><br>-Өндөр насны тэтгэвэр авч байсан тэтгэвэр авагч нас барсан бол түүний нөхөр/ эхнэр/-ийн өндөр насны тэтгэврийг **20** хувь нэмэгдүүлэн тооцож нийт **3** тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтоосныг хянаж баталгаажуулсан.<br><br>- Хил хамгаалах ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хооронд хамтран ажиллах 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 03/22/23 тоот санамж бичгийн хүрээнд Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон **1** цэргийн алба хаагч эхийн хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацааг цэргийн байгууллагаас гаргасан архивын лавлагаа, чөлөө олгосон тушаалыг үндэслэн цэргийн тэтгэврийг тогтоосон.<br><br>- Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 450 дугаар тогтоолоор баталсан "*Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг* |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | *өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам*"-ыг баримтлан ажиллаж байна.<br><br>- Монгол улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/221 тоот тушаалаар баталсан "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт" –г хэрэгжүүлэн ажиллаж нийт **8** тэтгэврийг хянаж баталгаажуулсан.<br><br>-Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 469 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Нийгмийн даатгалын улсын байцаагчийн дүрэм"-ийн дагуу улсын байцаагчийн актыг хүчингүй болгуулахаар **2** тэтгэвэр авагчийн хувийн хэргийг НДЕГ-т шилжүүлсэн.<br><br>- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн тушаалаар баталсан "Итгэлцүүр хэрэглэх журам"-ын дагуу Цэргийн албан хаагч нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон **5** тэтгэвэр авагчийн цэргийн албан хаасан хугацааны шимтгэлийг авч байсан цалин хөлс |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | түүнтэй адилтгах орлогыг итгэлцүүрээр өсгөн тооцсон дүнгээс тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын санд төлүүлсэн. |

ХОЁР. "ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

***Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр , тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах,өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах,нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох,нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах,гүйцэтгэлийг тайлагнах.***

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.1.2 | Шинээр болон өөрчлөн тогтоолгох тэтгэврийн материалыг хүлээн авч, тогтоосон тэтгэврийг хянаж баталгаажуулах | Шинээр болон өөрчлөн тогтоосон тэтгэврийг хянасан тоогоор | Шинээр болон өөрчлөн тогтоосон тэтгэврийг хуулийн хугацаанд хянаж баталгаажуулсан байна | 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт **4122** хувийн хэргийг хянаж баталгаажуулсан. **Шинээр** нийт **541** тэтгэврийг хянаж баталгаажуулсан. Үүнд:<br>Цалинд суурилсан өндөр насны тэтгэвэр- **378**<br>Цэргийн алба хаасны тэтгэвэр- **22**<br>Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр-**93**<br>Тэжээгчээ алдсаны тэтгэвэр-**48**<br>***Тэтгэврийн өөрчлөлт.***<br>Дундаж цалингаа 5 жилээр өөрчлөн тогтоолгосон-**2865** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | Ажилласан жилийн нэмэгдэл-485<br>ХЧАТ-ийн хугацаа сунгалт-231 |
| 2.1.4 | Дотоодын хяналт шалгалт, НДЕГ, ННДГ болон хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн төлбөр,зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд гаргах | Тогтоосон акт, барагдуулалтын хувиар | Хуваарийн дагуу тогтооосон актыг 30 хувиар бууруулсан байна. | Дотоодын хяналт шалгалтын **15** тэтгэвэр авагчтай холбоотой **67.1** сая төгрөгнөөс **17.1** сая төгрөгийг буюу **25.5** хувиар барагдуулсан.<br><br>ННДГ-ын 2023 оны 04 дүгээр сарын 27-ний өдрийн 31/12 тоот улсын байцаагчийн актаар **/30,1** сая төгрөгийн / зогсоосон Р.Баттулгын ажилласан жилийн тушаалын үндэслэлд дүн шинжилгээ хийж, ННДГ-т танилцуулан шалгуулж гарсан шийдвэрийг үндэслэн улсын байцаагчийн 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 23000008, 23000009 тоот актаар **5,7** сая төгрөгийг нөхөн олгож, **1,5** сая төгрөгийг буцаан төлүүлж 2023 оны 08 дугаар сарын 01-ны өдрөөс өөрчлөн тогтоосон. |

## ГУРАВ." ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ "ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

*Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалынорон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах*

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.2.2 | Хил хамгаалах ерөнхий газартай2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/НД-22/23 дугаартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэж дүгнэх. | Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг хагас, бүтэн жилээр гаргаж 2024 оны 6 дугаар сарын 1,12 дугаар сарын 1-ний өдрөөр тасалбар болгон тайлагнах, илэрсэн зөрчил дутагдлыг 70 аас доошгүй хувийг барагдуулсан байх. | Холбогдох судалгаа, тооцоо,дүгнэлтэнд үндэслэн Хилийн цэргийн анги, тусгай салбартай хамтарсан шалгалт хийж үр дүнг тооцож ажилласан байх | Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон 1 цэргийн алба хаагч эхийн хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацааг цэргийн байгууллагаас гаргасан архивын лавлагаа, чөлөө олгосон тушаалыг үндэслэн цэргийн тэтгэврийг тогтоосон. |
| 3.2.1 | Төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж хэвших. | Хуулийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах | Хөрөнгө орлогод орсон их хэмжээний өөрчлөлт болон ажил албан тушаал өөрчлөгдөх үед хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг тухай бүр гаргаж хэвшсэн байна. | Хуулийн хугацаанд гаргаж баталгаажуулсан. |
| 3.2.2 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн | Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах. | 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан зорилтот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж, | 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгжийн даргатай байгуулж, гүйцэтгэлийн биелэлтийг /эхний хагас жил/ 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр гаргасан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | түвшинг үнэлэх журмуудыг хэрэгжүүлэн ажиллах | | хугацаанд нь биелэлтийг гаргасан байна. | |
| 4.4.3 | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах | Программ хангамжуудыг зөв зохистой ашиглаж,аюулгүй байдлыг хангах | **SICOS** шинэчлэгдсэн программыг ашиглах | **SICOS** шинэчлэгдсэн программыг ашиглахтой холбоотой дээд гарзаас ирүүлсэн заавар, чиглэлийг мөрдөж ажиллаж , аюулгүй байдлыг хангаж 1 удаа нууц кодоо сольж ажиллалаа. |

## ХОЁР. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| 1 | Үүрэг даалгавар 2 | Өгсөн субьект 3 | Биелэлт 4 |
|---|---|---|---|
| | НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ | | |
| 1.1.1 | Тогтоогдсон тэтгэмжийг мэдээллийн баазтай тулган шалгаж баталгаажуулах | Нэгжийн даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу тэтгэмж хянасан тоогоор | 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт **550** тэтгэмжийг хянаж ббаталгаажуулсан. Үүнд: ХЧТА-**250**, эмчийн хяналт-**300**. |
| | ХОЁРДУГААР УЛИРЛЫН НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ | | |
| 2.1.1 | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах | Нэгжийн даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн тоогоор | 2024 оны 01-02 дугаар улирал нийт **85** байгууллага, даатгуулагчтай холбоотой өргөдлийг хүлээн нөхөн тайлантай холбоотой **32**, тайлан залруулахтай холбоотой **43**, бусад чиглэлээр **10** нийт **125** даатгуулагчийн өргөдөл, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. |

## ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | |
|---|---|---|---|
| | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин/ биелэлт |
| "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ,ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | |
| 1 | Сурах мэдлэгээ дээшлүүлж,сургалтанд хамрагдах. | Хамрагдсан сургалтын тоогоор | Дээд газраас зохион байгуулсан цахим сургалтанд тогтмол хамрагдсан ./5 удаа/ |
| 2 | "Монгол бичгийн үндэсний бичгийн хөтөлбөр-3"-ыг хэрэгжүүлэх болон Төрийн албан хэргийг 2025 оноос хос бичгээр явуулах ажлын хүрээнд | Хамрагдсан сургалтын тоогоор | https://mongol-bichig.nso.mn Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох 2 дахь шатны судалгаанд хамрагдсан.. |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХШДАТ-ИЙН БАЙЦААГЧ А.ЭНХЖАРГАЛ 2024.05.27

92